



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



**САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ
ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.**

**Даланзадгад сум
2019 он**



Аудитыг гүйцэтгэсэн:

Агуулга

Хуудас

Дарга тэргүүлэх аудитор
П.Алтанзаяа

Товчилсон үгийн тайлбар

2

Аудитын менежер
Ж.Болормаа

Аудитын зорилт, арга зүй, стандартын
талаарх мэдэгдэл

3-4

Ерөнхий мэдээлэл

5-6

Ахлах аудитор:

Т.Хонгорзул

**Бүлэг 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
сангийн үр дүнг тооцох ажил хангалтгүй
байна.**

7-12

Аудитор:

П.Батцэцэг

**Бүлэг 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
сангийн хэрэгжилтэд тавих дотоод
хяналт үр нөлөөгүй байна.**

13

Ч.Наранбадрах

Дүгнэлт

14

Холбогдох байгууллагын санал

15

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын
тушаал

16

2019 оны 7 дугаар сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70533539 дугаарын
утсаар харилцана уу.

Тайланг ӨМТАГ-ын
www.Umnugovi@audit.gov.mn
цахим хуудаснаас үзнэ
үү.

Хаяг:
Нутгийн удирдлагын
ордон, 3 давхар 303 тоот



ТОВЧИЛСОН ҮГ

ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ТББ	Төрийн бус байгууллага
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын Орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?*
- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?*

Хамрах хүрээ:

Аудитаар Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс хамрагдав.

Аудитын арга зүй:

Аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын урьдчилсан судалгааны явцад хэрэгжүүлсэн горим, сорил, дүн шинжилгээ, ярилцлагын явцад тодорхойлогдсон эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй болно.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.

- Төсвийн тухай хууль,
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр,
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр,
- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
- Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр,
- Холбогдох бусад тогтоол шийдвэр



**Аудит
хийсэн
багийн
бүрэлдэхүүн**

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Алтанзаяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Болормаа хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хонгорзул, аудитор П.Батцэцэг, Ч.Наранбадрах нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

**Аудитын
хугацаа**

Аудитын 2019 оны 04 дүгээр сарын 01-нд эхэлж, 7 дугаар сарын 01-ны хугацаанд хэрэгжүүлэв.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2011 онд байгуулагджээ. Тус сангийн үйл ажиллагааны зохицуулалттай холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулж, 2012, 2014, 2015, 2016, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар тусгай сан байгуулж, Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрөөс сангийн орлогыг бүрдүүлэхээр заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн удирдамжийг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэгдсэн төсвийг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийн хуваарийг баталж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар тус сан нь өөрийн орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар ажиллаж, сангийн гол орлогоо гадаадаас Монгол Улсад ажиллаж байгаа иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогоос бүрдүүлж, зарлага нь улсын болон орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүйгээр ажилгүй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг байнгын болон түр ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлдэг Засгийн газрын тусгай сан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх олон төрлийн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор 2018 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдуулан хүснэгтэд дурьдсан нэр бүхий төсөл хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

№	Хөтөлбөрийн нэр
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
2	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр

ХЭДС-ийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийг мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсрогуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн



бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулдаг байна.

2018 онд ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт 853.5 сая төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 138.3 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 209.1 сая төгрөг бусад орлого 0.6 сая төгрөг нийт 1,201.5 сая төгрөгийн санхүүжилт авч, хөтөлбөрүүдэд 703.8 сая төгрөг зарцуулж, 497.7 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.



БҮЛЭГ 1 **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үр дүнг тооцох ажил хангалтгүй байна.**

Зарим хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хэрэгжих үр дүнг тодорхой болгох шаардлагатай байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр



Хөтөлбөр нь хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.


- 1.1. Тайлант онд ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт 41 иргэнд 108.0 сая төгрөг, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд 42 иргэн хамруулж 1.2 сая төгрөг, борлуулалтын дэмжлэг 1.8 сая төгрөг, 2 иргэнд ажлын байрны дэмжлэг олгоход 2.4 сая төгрөг, ажил олгогчид дэмжлэг болгон 5.7 сая төгрөг, нийтийг хамарсан ажилд 313 иргэн хамруулж 57.4 сая төгрөг, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалахад 34 иргэнийг хамруулж 16.0 сая төгрөг нийт 192.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- 1.2. Хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 35-аас дээш насны иргэдийн санхүүгийн дэмжлэг авах хүсэлт ирүүлсэн 64 иргэний төсөлд урьдчилсан хяналтыг зохион байгуулсан байна.
- 1.3. Ажил идэвхтэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа 2 иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан 2 ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх урамшуулал 5.7 сая төгрөг олгосон байна.
- 1.4. Хувиараа аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 35 болон түүнээс дээш насны 41 иргэний төслийг шалгаруулж гэрээ байгуулан 108.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүжилтийг олгож, 41 байнгын ажлын байр бий болгож ажиллажээ.
- 1.5. Эргэн төлөлтийн графикын дагуу 2018 оны эцэст 25.4 сая төгрөг төлөгдөхөөс 13.4 сая төгрөг төлөгдөж 11.6 сая төгрөг төлөгдөөгүй үүнээс 9 иргэн төлбөрөө огт төлөөгүй байна.
- 1.6. Энэ нь төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, эргэн төлөлт хийх төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах, эргэн төлөлт хийх хуваарийн дагуу төлөлт хийхийг шаардаж ажиллаагүйг харуулж байна. Аудитын явцад зарим төсөл



хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг шалгаж зориулалты дагуу зарцуулж буйд тулган баталгаажуулалт хийлээ.



Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр



shutterstock · 137450330

Малчин өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийн хүрээнд Баяндалай сумаас 5, Баяновоо сумаас 4, Булган сумаас 4, Номгон сумаас 2, Мандаловоо сумаас 5, Сэврэй сумаас 2, Ханхонгор сумаас 2, Хүрмэн сумаас 3, Цогт овоо сумаас 3, Цогтцэций сумаас 5, Даланзадгад сумаас 7 малчин өрх шалгаруулж нийтдээ 42 малчин өрхөд 201.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хийх хуваарь 2019 оны 06 дугаар сараас эхлэн 2020-2021 онд төлж дуусахаар төлөвлөгөө гарган ажилласан

байна.

- 1.1 Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд төрийн болон ААНБайгууллагад ажилладаг 6 иргэн санхүүгийн дэмжлэг авсан байгаа нь малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “малчин өрхийг малжуулах” гэдгийг зөрчсөн байна. Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өглөө.
- 1.2 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь Технож Бизнес Инкубатор Төвтөй хамтран Залуу малчдыг бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжлэг болох үүднээс мал маллагааны арга, шилдэг туршлагаас судлуулах үүднээс хөтөлбөрт хамрагдсан малчдаас 10 залуу малчны төлөөллийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны нийслэл “Хөх



хот” чиглэлд туршлага солилцох уулзалт арга хэмжээнд хамруулан 9.1 сая төгрөг зарцуулж ажилласан байна.

- 1.3 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчдад аж ахуй эрхлэх сургалт зохион байгуулах зардалд 2.1 сая төгрөг зарцуулсан байна.



Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлийн үр чадвар олгох хөтөлбөр

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр нь ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олгоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, 15-34 насны залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх

арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох сургалтанд хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн зорилгын хүрээнд дээрх зорилтот бүлгийн хамрах хүрээний иргэдийг сургалтанд хамруулсан байна.

- 1.1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрт нийт 25.2 сая төгрөг зарцуулахаар төсөв батлагдсанаас 142 хүнд 13.2 сая төгрөгийг зарцуулж ажилласан байна.
- 1.2. Хөтөлбөрийн хүрээнд Политехник коллежтэй хамтран “Тогооч бэлтгэх” 30 хоногийн түр сургалтанд зорилтот бүлгийн 17 ажилгүй иргэнийг хамруулан сургалтыг зохион байгуулж 11 иргэн сургалтыг амжилттай дүүргэж чадамжийн гэрчилгээ авсан байна.
- 1.3. Мэргэжлийн болон давтан сургалтын хөтөлбөрийн хүрээнд Политехник коллежтэй хамтран “Дампын операторчин” мэргэжлээр 17 ажилгүй иргэнийг хамарсан сургалтыг зохион байгуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

№	Сургалтын нэр	Гэрээний дүн	Сургалтын байгууллагын нэр	Хүний тоо	Товч агуулаа
1	Хөдөлмөрт бэлтэх сургалт	3,600,000	Хөгжлийн хөтөч Оюутан залуучуудын холбоо ТББ	80	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдах
2	Хөдөлмөрт бэлтэх сургалт /Тогооч бэлтгэх	1,320,000	Политехник коллеж	17	Бизнес төслийн тухай ерөнхий ойлголт, бизнес санааг эрэлхийлэх, тэдгээрийг үнэлэх,
3	/Хүлэмжийн аж ахуй эрхлэх/	2,136,000	Ирмүүн сургалтын төв	20	Хүлэмжийн аж ахуй эрхлэх
4	Мэргэжлийн болон давтан сургалт	6,160,000	Политехник коллеж	25	Дампын операторчин
		13,216,000		142	



- 1.4. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд 4 төсөл арга хэмжээнд зориулан 13.2 сая төгрөгийг 142 хүнийг хамруулжээ.
- 1.5. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлж хөдөлмөрт бэлтгэх, ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг бүрэн хамруулж мэргэжлийн болон давтан сургалтанд хамруулж чадамжийн гэрчилгээ олгосон байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хүрэх ёстой үр дүнг бүрэн тооцож хэрэгжилтийг бүрэн тайлагнаж ажиллаагүй байна.
- 1.6. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг бүртгэлжүүлэн ажилгүйдлийн тоо буурсан эсэх талаарх нарийн тооцоо судалгаа хийгдээгүй, эргэх холбоогүй ажилласан байна.
- 1.7. Дээрх зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр



Уг хөтөлбөрийн зорилго нь залуучууд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байртай болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэгдсэн байна.

- 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч 15-24 насны залуучуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй төслийг зарлан шаардлагад нийцсэн төслийг сонгон шалгаруулж 54.0 сая төгрөг, “Хөгжлийн Шийдэл” ТББ-тай хамтран ажил хайгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд аж ахуй эрхлэлтийн талаар сургалтыг зохион байгуулж 9.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2018 онд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /мян.төг/
Төлөвлөсөн зардал /мян.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал /мян.төг/	Хамруулсан хүний тоо	
75,400.0	80	63,468.2	192	11,931.8

- 1.2. Хөтөлбөрт зарцуулагдаагүй үлдсэн 11.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
- 1.3. Хөтөлбөрийн хүрээнд: Өмнөговь аймгийн 15-34 насны 60 залуучуудын дунд зохион байгуулж, 40 шинэлэг санаа дэвшүүлснээс 6 багийн төслийг шалгаруулсан байна. Үүнд:
 - “Power” багийн машин тоног төхөөрөмжийн агаар шүүгч цэвэрлэх төсөл
 - “Түлхүүр” багийн тэмээн тохом үйлдвэрлэл, дархан хийц төсөл



- “Hostel” багийн суурин ба нүүдлийн аялал жуулчлал
 - “Сувд” багийн гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - “Smart chain” багийн тэжээвэр амьтны ухаалаг хүзүүвч
 - “Эко цаасан уут” багийн цаасан уутны үйлдвэрлэл
- 1.4. Залуучууд болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдөд аж ахуй, бизнес эрхлэхэд гарааны болон санхүүгийн дэмжлэг олгосноор байнгын ажлын байртай болсон гэх боловч орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа төсөл байхгүй байлаа. Энэ нь ихэвчлэн оюутан залуучууд хамрагддаг учраас орон нутагт байнга үйл ажиллагаа явуулах боломжгүй гэх тайлбарыг өгч байлаа.
- 1.5. Хөтөлбөрийн үр дүнд: Хэрэгжүүлсэн төслийн үр өгөөж, хэрэгжилтийн явц, зээлийн эргэн төлөлт, зэрэг хөтөлбөрийн үр дүнг тооцохгүй, дотоод хяналт хийгдэхгүй байгаа зэрэг нь хөтөлбөр үр дүнгүй хийгдэх эрсдэлийг нэмэгдүүлж, үр өгөөжийг бууруулж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт 62.5 сая төгрөг зарцуулахаар төсөв батлагдсанаас 81 хүнд 47.5 сая төгрөгийг зарцуулж ажилласан байна.

- 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтыг хэрэгжүүлэн зорилтот бүлгийн 13 хүнд 40.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг олгосон байна.
- 1.2. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хөдөлмөрт бэлтгэх сургалтанд 68 хүнийг хамруулжээ.
- 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхэлдэг 13 иргэнд 40.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг хууль, журмын дагуу олгож ажилласан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих зээл олгосон байдал

№	нэр	дүн	сум	хугацаа	ХБИргэний комиссын акт
1	Б.Саранчимэг	3,000,000.0	Цогтцэций	4 жил	2019.04.05
2	Г.Бямбасүрэн	3,000,000.0	Цогтцэций	4 жил	2018.10.05
3	О.Цэнджаргал	4,000,000.0	Баян-Овоо	4 жил	2018.10.08
4	Л.Идэрцог	3,500,000.0	Булган сум	4 жил	2019.01.08
5	Д.Мөнхбаатар	4,000,000.0	Булган сум	4 жил	2019.07.15
6	Э.Ганцэцэг	2,000,000.0	Сэврэй сум	4 жил	2019.03.22
7	Н.Баярсайхан	2,300,000.0	Сэврэй сум	4 жил	2019.03.05



8	Д.Ганзаяа	3,000,000.0	Ханбогд сум	4 жил	2019.02.05
9	Л.Өлзийцэцэг	1,200,000.0	Даланзадгад	4 жил	2018.12.18
10	А.Төрбат	4,000,000.0	Даланзадгад	4 жил	2018.06.15
11	П.Хишигжаргал	4,000,000.0	Даланзадгад	4 жил	2019.02.06
12	Б.Оюундэлгэр	3,000,000.0	Даланзадгад	4 жил	2018.12.01
13	Ц.Баттүвшин	3,000,000.0	Даланзадгад	4 жил	2019.04.30
		40,000,000.0			

- 1.4. Нэр бүхий 13 иргэнд 40.0 сая төгрөгийн зээлийг 4 жилийн хугацаатай олгож гэрээний хавсралтаар эргэн төлөгдөх хуваарийг зээлдэгчээр өөрсдөөр нь гаргуулан авч баталгаажуулан ажилласан байна.
- 1.5. Хөтөлбөрт хамрагдсан байдлыг товч дурдвал:
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Хөдөлмөрт бэлтгэх сургалтын хүрээнд 15 зорилтот бүлгийн иргэнд 5 хоногийн сургалтыг явуулсан байна. Сургалтаар хувь хүний эерэг харилцаа хандлага, хувцаслат гоо зүй, өөрийгөө үнэлэх, ажил хөдөлмөрт өөрийгөө бэлдэх, ажил хайхад хэрэгтэй бичиг баримтуудаа боловсруулах, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзлэлийг төрүүлэх, ажил олгогчийн тавьдаг ерөнхий шаардлагууд, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн гэрээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүй, ажил мэргэжил сонгоход зөвлөгөө өгөх гэх мэт сэдвүүдийн хүрээнд өргөн цар хүрээтэй зохион байгуулагдсан байна.
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Өмнөговь-д үйлдвэрлэв” борлуултын цэгийг “Ивээл” болон “Хөгжил” худалдааны төвүүд дээр нээн ажиллуулсны байрны түрээсийн төлбөрт 3.600.000 төгрөгийн зардыг түрээслэгч байгууллагад олгож ажилласан байна.
 - ✓ Аж ахуй эрхлэх, жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтын хүрээнд 53 зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй буюу тэдний асран хамгаалагч иргэдэд 5 хоногийн сургалтыг явуулсан байна. Сургалтаар жижиг зээлийн төсөл боловсруулах арга зүй, төрөөс хэрэгжиж буй хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл, бизнес санаагаа хөгжүүлэх, SWOT шинжилгээ хийх арга зүй, маркетингийн жижиг хэмжээний судалгаа хийх, аж ахуй эрхлэх хууль эрх зүйн орчин, борлуулалтаа урьдчилан төсөөлөн өртөг ашгаа тодорхойлох, орлого зардлын тухай ялгаа, бизнесийн мөнгөн урсгалыг хянах, борлуулалтын тайлан үр дүнг гаргах, зээл авах эргэн төлөх мөнгөн урсгалын төсөв гэх мэт сэдвийн хүрээнд зохион байгуулж ажилласан байна.
- 1.6. Зарим хөтөлбөр арга хэмжээнд гэрээ байгуулсан боловч хэрэгжилтийг бүрэн тооцож ажиллаагүй байна. Нэр бүхий 13 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 40.0 сая төгрөгийн зээлийг авсан бөгөөд 2018 онд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн 4 иргэн байна. Бусад 9 иргэнээс 4 иргэн 2018 онд огт төлөлт хийгээгүй буюу гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, 5 иргэн 17-96 хувийн төлөлт хийсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлтийн судалгаа /2018 он/



№	нэр	регистр	Төлөх	Төлсөн	Хувь
1	Б.Саранчимэг	КЮ84092801	750,000	-	-
2	Г.Бямбасүрэн	КН01281005	750,000	125,000	16.7
3	О.Цэнджаргал	КБ74030519	999,600	499,800	50.0
4	Л.Идэрцог	КВ67110214	511,000	-	-
5	Д.Мөнхбаатар	КВ76120911	581,000	555,000	95.5
6	Э.Ганцэцэг	КИ82051806	450,000	450,000	100.0
7	Н.Баярсайхан	КИ96010110	450,000	450,000	100.0
8	Д.Ганзаяа	КИ81041969	750,000	-	-
9	Л.Өлзийцэцэг	МА69090101	150,000	150,000	100.0
10	А.Төрбат	КЮ81051219	100,000	-	-
11	П.Хишигжаргал	КЮ64083078	500,010	501,500	100.3
12	Б.Оюундэлгэр	КЮ70111005	375,000	63,000	16.8
13	Ц.Баттүвшин	КЮ67052775	375,000	312,500	83.3
дүн			6,741,610	3,106,800	46.1

- 1.7. Хүснэгтээс харахад 2018 онд зээл авсан 13 иргэн гэрээний дагуу 6.7 сая төгрөг төлөхөөс гүйцэтгэлээр 3.1 сая төгрөгийг төлж 46 хувийн барагдуулалттай ажилласан байна.
- 1.8. Аудитын явцад зээлийн эргэн төлөлтөө хугацаандаа хийхгүй байгаа төсөл хэрэгжүүлэгчтэй уулзаж, төслийн явцыг шалгалаа.



**Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг
хэрэгжүүлэх хөтөлбөр**


Хөтөлбөрийн зорилго нь ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байна.

- 1.1. Хөтөлбөрийн дагуу 5 иргэнд эргэн төлөх нөхцөлтэй 12.0 сая төгрөг, зөвлөн туслах үйлчилгээ авах хүсэлтэй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран



ажиллах гэрээний дагуу 14.5 сая төгрөгийн санхүүжилт олгож ажилласан байна.

- 1.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 3 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд хөтөлбөр хэрэгжүүлэх зар мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбаруудад зар мэдээллийг байршуулан иргэдэд нээлттэй зарлан мэдээллэж ажилласан байна.
- 1.3. Төсөл зарлагдсан хугацаанд ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдийн 21 төсөл хүлээн авч 5 төслийг сонгон шалгаруулсан байна. Үүнд: ногоо тариалах, бариа засал, гар урлал, гоо сайхан, фото зургийн чиглэлээр байнгын ажлын байрыг бий болгох тогтмол үйл ажиллагаа явуулж байна.
- 1.4. Зөвлөн туслах үйлчилгээ авах хүсэлтэй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 26 ахмад мэргэжилтэн эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, төрийн захиргааны чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлжээ.
- 1.5. Хөтөлбөрийн нэр “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” гэсэн боловч тодорхой хэдэн чиглэлээр эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгогдож байгаа нь хөтөлбөрийн нэр, үйл ажиллагаатай уялдахгүй байгаад зөвлөмж хүргүүлээ.
- 1.6. Тайлант онд олгогдсон төсөл хөтөлбөрийн зориулалт үйл ажиллагааг шалгаж тулган баталгаажуулалт хийлээ.





2 БҮЛЭГ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

- 2.1. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын 2018 оны 03 сарын 22-ны өдрийн тушаалаар 2018 онд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.
- 2.2. Батлагдсан төлөвлөөний дагуу хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан хэрэгжүүлсэн боловч хэдэн удаа хяналт хийсэн, шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, дүгнэлт зөвлөмж боловсруулсан нотлох баримт байхгүй байна.
- 2.3. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдсон төсөл хөтөлбөрийн явц, үр дүнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 2.4. Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нар эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдсон зээлийн төлөлтийн байдалд дүн шинжилгээ хийдэггүй, үр дүнг нарийн тооцохгүй байгаад зөвлөмж өглөө.
- 2.5. Иймд дотоод хяналт-үнэлгээг чанаржуулж, төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байгаа тухай албан шаардлага өглөө.



Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Зарим хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хэрэгжих үр дүнг тодорхой болгох шаардлагатай байна.
2. Эргэн төлөх нөхцөлтэй гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
3. Хөтөлбөрт шаардлага хангаагүй зарим иргэдийг сонгон шалгаруулсан байна.
4. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс төслийн явцын тайлан авдаггүй, хуваарийн дагуу төлөлт хийгддэггүй, зээлийн эх үүсвэрийн ашиглалт, зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих байдал хангалтгүй байна эргэн төлөлтийн биелэлтэнд хяналт тавьж ажиллаагүй байна.
5. Дотоод хяналт-үнэлгээг чанаржуулж, төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар анхаарч үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.



Тайлан баталгаажуулах тушаал



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 25

Даланзадгад

Аудитын тайлан баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2, мөн 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 2.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга /Х.Сугир/, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга /Б.Должинсүрэн/ нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 4 дүгээр улиралд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний даргад зөвлөсүгэй.
4. Албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Ж.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.АЛТАНЗАЯА

D:Bichig hereg/Tushaal-A4